



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар A/65

Халбан

**Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл
олгох тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэг, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, Монгол Улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/151 дугаар тушаал зэргийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд хүүхэд харах үйлчилгээ эрхлэх гэж буй Ц.Энхсүрэн, Ж.Батжаргал, Ц.Энхчимэг нарт тус сумын 5 дугаар баг, Буриа 9-9в тоотод хүүхэд харах үйлчилгээ эрхлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хүүхэд харах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагыг хангаж ажиллаж байгаа эсэхэд байнгын хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Ч.Амарбаясгалан)-д үүрэг болгосугай.

3. Хүүхэд харах үйлчилгээний нийтлэг шаардлагыг хангаж ажиллахыг хүүхэд харагч (Ц.Энхсүрэн), (Ж.Батжаргал), (Ц.Энхчимэг) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-д даалгасугай.

ДАРГА  Н.АНХБАЯР

